

ДУНДГОВЬ АЙМАГ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЧМЭЛ ТАЙЛАН**

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРААС 2024 ОНД

ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 сарын 23 өдөр

Мандалговь

НЭГ. БАЙГУУЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА, УДИРДЛАГА ЗОХИОН

БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ

ХХААХҮЯамны сайдын 2023 оны А/18 дугаар тушаалын дагуу Хүнс, Хөдөө аж ахуйн газар нь Мал аж ахуйн алба, Захиргаа аж ахуйн алба, Үйлдвэр, худалдаа үйлчилгээний алба, Хяналтын алба нийт 4 алба 22 орон тоотойгоор орон нутагт ХХААСалбарын бодлого шийдвэр, хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХХААХҮсайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээ-91,5 %, Дундговь аймгийн Засаг дарга, ХХААГ-ын даргатай байгуулсан гэрээ-100 %, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр -98 %,ХХААГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт-91,2%, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт-94,5 %, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр-94,7 %, Байгууллагын стратеги төлөвлөгөө- 91,8% , Аймгийн стратеги төлөвлөгөө-86 % бодлогын баримт бичгийн хэрэгжилт 93,7 хувьтай тус тус хэрэгжүүлэн ажилласан.

Аймгийн Засаг даргын тамгын газраас 2024 оныг “Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын жил болгон зарласантай холбогдуулан тус байгууллагаас зорилтот жилийн хүрээнд хийж хэрэгжүүлэх 5 зорилт 9 арга хэмжээг төлөвлөн Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг 100% ханган ажилласан. Онцолж хийсэн ажлаас дурьдвал: Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор албан хаагчид болон хүүхдүүдэд уртын дууны хичээлийг мэргэжилтэн уртын дууч Р.Галбадрах сард нэг удаа зохион байгуулж, сургалтад 5 хүүхэд, 8-н албан хаагч хамрагдаж байна.“Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлж 12 ажилчдын 18 хүүхдүүдийг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, зохих эмчилгээг хийлгэсэн.

Мөн байгууллагын нийт албан хаагчдад мэргэжилтэн Р.Галбадрах “Архи үгүй амьдрал-Аз жаргал” сэдэвт сургалтыг зохион байгуулж сурталчилсан. Энэ үеэр мөн аймгийн “Говийн хийморь” бүлэг, **АА** төвийн үйл ажиллагаа зохион байгуулалтын талаар сурталчилгаа танилцуулга хийсэн.

Хоёр. Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр:

Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” хөтөлбөрт тусгагдсан зорилт арга хэмжээг тус байгууллагад хэрэгжүүлэх 2 зорилт 11 арга хэмжээг төлөвлөн газрын даргаар батлуулж 94,5 хувьтай хэрэгжүүлэн ажилласан.

ХХААСалбарын мэргэжилтэй боловсон хүчин 60 байхаас 33 албан хаагч ажиллаж, мэргэжилтэй боловсон хүчний хангалт 56,8 хувьтай байна.


ХХААГазарт 13, сумдын ХААТасагт 15 албан хаагч, нийт 28 албан хаагч 3-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа нь хөдөө аж ахуйн салбарт одоо ажиллаж байгаа нийт албан хаагчийн 70 хувийг эзэлж байна.

Төрийн захиргааны 33 албан хаагчийн 22 буюу 66,6 хувь нь эмэгтэй, 11 буюу 33,3 хувь нь эрэгтэй албан хаагч ажиллаж байна.

Насны ангиллаар авч үзвэл 35 хүртэл насны залуучууд 9 буюу 27,2 хувь 35 дээш насны албан хаагчид 19 буюу 57,5 хувийг 45 дээш насны 5 албан хаагч 22,7 хувийг эзэлж байна.



Төрийн албанд ажилласан жилээр авч үзэхэд нийт албан хаагчдын 82 хувь нь 5 дээш жил тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид байна.



Тус газрын мал үржлийн албанд **Малын генетик нөөцийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, ялган тэмдэглэгээ** хариуцсан мэргэжилтний сул орон тоо гарч Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалтыг үндэслэн сонгон шалгаруулалтыг зарлуулж, сонгон шалгаруулалтад ХААИС-ийн Зоо инженер технологийн ангийг төгссөн М.Балжинням тэнцэж, сул орон тоо хуулийн дагуу нөхөгдсөн.

Захиргаа аж ахуй албаны Хүний нөөц, тайлан, мэдээ, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтний сул орон тоо гарсныг Төрийн албаны салбар зөвлөлд хуулийн хугацаанд захиалгыг хүргүүлж зарлуулан ажиллаж байна.Одоогоор нөхөгдөөгүй байна.

Сумдын хөдөө аж ахуйн тасагт нийт 19 албан хаагч ажиллаж байна. Дутагдалтай байгаа албан хаагч 26, боловсон хүчний хангалт 42,2 хувьтай байгаа нь тулгамдаж буй асуудлын нэг болоод байна. Сумдын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн 3 мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах гэж байгаатай холбогдуулан сумдаас гарсан төслийн саналыг нэгтгэн ХХААХҮЯамны Төрийн захиргааны удирдлагын газарт хүргэсэн. Сумдаас гарсан санал нь албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан мэргэжлийн индексийг нийтлэг байдлаар оруулах шаардлагатай, нарийн мэргэжил зааснаас сул орон тоо нөхөгдөхгүй гол шалтгаан болж байна гэсэн саналыг сумдаас ирүүлснийг уламжилсан.

Орон нутагт боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр сумд болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж ирсэн. Дундговь аймаг дахь Политехникийн коллежийн “Мал зүйч”-ийн ангид 5 сумаас нийт 9 иргэн суралцаж анхны төгсөлтөө хийх гэж байна. Цаашлаад оюутнууд ХААИСургуулийн Зоо инженер технологийн ангид 1,5 жилээр суралцаж дээд мэргэжилийг эзэмшиж төгсөнө. ХААИС-ийн МААБТСургуулийн бакалаврийн зэрэгтэй дэвшин суралцах гэрээг байгуулан хамтран ажиллаж байна. Өлзийт, Гурвансайхан, Дэлгэрцогт сумын ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасагт ажиллахаар 3 албан хаагч 2023 оноос эхлэн ХААИС-ийн “Зоо инженер технологи”ийн” 2,5 жилийн эчнээ ангид суралцаж 1-р курсээ төгссөн. Мөн 2024 онд ХААИС-ийн Зоо инженер технологийн ангийг төгссөн 1 оюутан сургалтын төлбөрийн 4,5 сая төгрөгийн дэмжлэгт хамрагдан одоо тус газарт ажиллаж байна. Аймгийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр болон сумын ЗДТГ-аас тус оюутнуудтай гэрээ байгуулж, оюутнуудын суралцах хугацааны сургалтын төлбөрт нийт 11,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажилласан. Нийт 4 албан хаагчид 16,0 сая төгрөгийн сургалтийн төлбөрийн дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна.

Байгууллагын сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу Төрийн албан хаагчийн ёс зүй, албан хаагчдад архив албан хэрэг хөтлөлтийн стандартын анхан шатны мэдлэг олгох сургалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны талаарх сургалт, Ер Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаарх сургалтыг 16 албан хаагчид 16 удаа зохион байгуулсан. Давхардсан тоогоор нийт 112 албан хаагчдад өөрийн ажил мэргэжилтэй холбоотой, танин мэдэхүйн мэдлэг олгох сургалтыг хийсэн.

Байгууллагын сургалтын хөтөлбөрийн хүрээнд ХАБ-1, Ёс зүйн сургалт-1, албан бичиг солилцооны дундын системийн ашиглалтын талаарх сургалт-1, мөн Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр зохион байгуулдаг 7:4:10 вебинар 19 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 109 албан хаагч, Удирдлагын академийн “Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад-2, ХААИС-ийн “Мал

зүйч” ангид-1 албан хаагч тус тус хамрагдаж байна. Мөн цаг үеийн холбогдолтой 37-н удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 271 албан хаагч хамрагдсан байна.

Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад ахлах нягтлан бодогч Б.Энхдөл суралцаж төгссөн. МҮАлбаны дарга Ж.Батбилэг ахлах түшмэл, давтан мэргэшүүлэх сургалтад ЖДҮХ хариуцсан мэргэжилтэн Ж.Мөнхбаяр нар хамрагдаж төгссөн.

“Хамтдаа суралцъя-Хамтдаа хөгжье” facebook групп нээж мал үржлийн албаны мэргэжилтэн Э.Уугандорж хариуцан тогтмол ажиллуулж мэдээлэл солилцож байна. Нийт 75 мэдээллийг байршуулж түгээсэн.

Байгууллагын албан хэргийг хос бичгээр хөтлөх ажлын хүрээнд байгууллагын хэвлэмэл хуудсыг аймгийн архивын тасгаар хянуулан стандартын дагуу ашиглаж байна.

Гурав . Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр хийгдсэн ажлаас

Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 2024 онд хэрэгжүүлэн 4 зорилт 11 арга хэмжээтэй төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан.

Албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах байгууллагын компьютер тоног, төхөөрөмжийн хангамжийг сайжруулах ажлыг ХХААХҮЯам, холбогдох төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж нийт 18,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Албан хаагчдын бичиг хэргийн зардалд 414,150 төгрөг нийт 18,7 сая төгрөгийн төсөв зарцуулсан.

2024 оны А/08 дугаар тушаалаар томилогдсон үнэлгээний багийн гишүүд 100 хувийн ирцийн бүрэлдэхүүнтэй хуралдаж Төрийн жинхэнэ албан хаагчдын хагас, бүтэн жилийн ажлыг үнэлж нийт 14 албан хаагчид 30-40 хувийн улирлын ажлын үр дүнгийн урамшуулалд 10,1 сая төгрөг олгосон. Төрийн албан хаагчдад 1,2,3-р улирлын ажлыг дүгнэж аймгийн ЗДТГ-аас олгож буй орон нутгийн нэмэгдэлд 29,4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал өгсөн байна.

Байгууллагын албан хаагчдыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд Монгол Японы хамтарсан эмнэлэгт нийт албан хаагчдыг хамруулж 4,8 сая төгрөгийг зхарцуулсан. Нийт албан хаагчид хамрагдсан. Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26,2 дахь заалтад тусгагдсаны дагуу тус байгууллагын нийт төсвийн 0,5 хувь буюу 3,5 сая төгрөгийг албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдах үйл ажиллагаанд зарцуулсан. Монгол-Японы хамтарсан эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд албан хаагчдыг 100 хувь хамруулсны дагуу 5 албан хаагч хэвтэн эмчлүүлж, 10 албан хаагч гадуур эмчилгээ хийлгэж нийт албан хаагчдын 71,4 хувь эрүүл мэнддээ анхаарч ажилласан байна. Дотоод журамд тусгагдсаны дагуу цалинтай чөлөө олгож ажилладаг

Аймгийн нэгдсэн эмнэлэгт 18-34 насны иргэдийн эрт илрүүлгийн үзлэгт 2 мэргэжилтэн хамрагдсан.

Нийт албан хаагчдаас 10 албан хаагч буюу 52,3 хувь нь өөрийн эзэмшлийн орон сууцанд, 10 албан хаагч буюу 47,6 хувь нь өөрийн гэрт, 1 албан хаагч түрээсийн байранд, 1 албан хаагч нийтийн сууцанд амьдарч байна.

Галлагаатай гэр, байшинд амьдардаг албан хаагч нарт тус бүр /600,0 төг/ түлээ, нүүрсний хөнгөлөлтийн дэмжлэг 6,0 сая төгрөгийг 10 албан хаагчид олгосон.

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу төрийн захиргааны Дэд зэрэг дэс түшмэл 2 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгосон. Нийт 20 албан хаагч төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд хамрагдаж 2%-21 % нэмэгдэлэй ажиллаж байна.

Төрийн жинхэнэ албан хаагч нарын хагас бүтэн жилийн ажлыг үнэлж нийт 14 албан хаагчид байгууллагаас 30-40 хувийн улирлын ажлын үр дүнгийн урамшуулалд 20,1 сая төгрөг, аймгийн ЗДТГ-аас олгож буй орон нутгийн нэмэгдэлд 39,4 сая төгрөг нийт 59,5 сая. төгрөгийг үр дүнгийн урамшуулал олгосон байна.

ХХААГ-ын төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ, шатлалын судалгааг гаргаж, газрын даргын 2024 оны Б/06 дугаар тушаалаар баталж, мөрдөн хэрэгжүүлж байна. Төрийн алба хаасны хугацааны нэмэгдлийг төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан албан тушаалын үндсэн цалингаас бодож олгож байна.

Албан хаагчдын ая тухтай ажиллах боломжийг бүрдүүлэн байгууллагын дотоод өнгө үзэмж сайжруулах, засвар үйлчилгээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2,4 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт, санхүүжилтээр “ЭЙЧ ДИ ЭС ЮУ” ХХК хариуцан гүйцэтгэж оффисын шинэ барилгыг ашиглалтад 2024 оны 12 сард багтааж Улсын комисс ажиллуулж хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.



Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуухүнс, хөдөө аж ахуйн газраас өглөөний дасгал болон хөгжөөнт тоглоомыг зохион байгууллаа.

Иргэдийн дунд идэвхтэй амьдралын хэвшил бий болгох, биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор 2024.12.16-ний өглөөний 07:00 цагт Биеийн тамир спортын зааланд хүрэлцэн ирсэн Төрийн албан хаагч, иргэдийн дунд дасгал

болон хөгжөөнт тоглоомыг ХХААГ-с зохион байгуулж, хөгжөөнт тоглоомд түрүүлсэн багт дархлаа дэмжих эко бүтээгдэхүүнийг бэлгэлсэн.

Дундговь аймгийн Засаг даргын 2024 оны 01 сарын 02-ны А/02 захирамжаар Монгол үндэсний бахархал болсон өв соёлоо түгээн дэлгэрүүлж, Монгол соёлын дархлааг бий болгох зорилгоор үндэсний дээл хувцсаа сар бүрийн 3 дахь долоо хоногийн лхагва гарагт өмсөж хэвшүүлэх уриалга гаргасны дагуу Үндэсний хувцсаа өмсөж төрийн үйлчилгээг үзүүлж ажилласан.

Монгол улс 27 дахь жилдээ нэгдэж байгаа “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” 16 хоногийн аянд Хүнс, хөдөө аж ахуйн газрын нийт албан хаагчид нэгдэж аяны талаар Захиргаа аж ахуйн албаны дарга Ж.Шинэ-Уянга Жендерийн тухай ойлголт болон “ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ 16 ХОНОГИЙН АЯН”-ны талаарх мэдээлэл танилцуулгыг нийт албан хаагч нарт танилцуулж аяны нээлтийг хийсэн. Нийт албан хаагч нар аянд нэгдэж аяны логотой зургаа авахуулж Дундговь аймгийн ХХААГ facebook хуудаст байршуулж, олон нийтэд сурталчлан ажилласан. Байгууллагын гадна үүдний хэсэгт аяны лого, уриалгыг байршуулж, аяны хугацаанд тус байгууллагаас үйлчилгээ авсан 32 иргэнд сурталчилан ажиллаа. Тус газрын 10 албан хаагч Жендерийн үндэсний хорооны Facebook хуудсанд нэгдүүлж мэдээлэл авч ажиллаж байна.

ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургууль, Агроэкологийн сургууль, Мал эмнэлгийн сургууль, ХХААГазар хамтран ерөнхий боловсролын 5-н сургуулийн 9-12 ангийн 302 сурагчидтай уулзалт зохион байгуулж, хөдөө аж ахуйн салбарын мэргэжлүүдийн талаар мэдээлэл хийсэн. Мөн энэ үеэр аймгийн "Хүний нөөцийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийг 12 дугаар ангийн нийт төгсөгчдөд танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан.

Хулд сумын иргэдэд 2024 оны 10 сарын 29 өдөр "Төрийн үйлчилгээг нэг цэгээс" хүргэх өдөрлөг арга хэмжээнд Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчид оролцож Хоршоо байгуулах, Хүнсний аюулгүй байдал, мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ сэдэвүүдээр 310 иргэнд мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Сар шинийн баяр болон ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын өндөр настангуудад хүндэтгэл үзүүлж нийт 21 ахмад настанд 5342190 төгрөгний дэмжлэг үзүүлсэн.

Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд оролцлоо. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран зохион байгуулж байгаа Стратегийн команд штабын сургуулийн дохиогоор ажиллах дадлага сургуульд байгууллагын дэргэдэх "Хүнсээр хангах алба" жагсаж бэлэн байдлыг ханган оролцсон.

Байгууллагын “Ногоон байгууламж”ийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх 4 заалт бүхий төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг 100 хувь

ханган ажилласан. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөн "Хүнсний хангамж аюулгүй байдал"-ын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд улсын төсвийн 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрыг түшиглэн 3 га талбайд жимс, жимсгэний суулгац үржүүлгийн плантаци төв байгуулсан. Үржүүлгийн төвд улиас 175 ширхэг, хайлаас 700 ширхэг нийт 3 эгнээ 875 ширхэг хамгаалалтын ойн зурвас, 7 төрлийн жимс жимсгэнийн суулгац 1500, нийт 2375 ширхэг суулгацыг өнгөрсөн жил суулган хүлээн авч, арчилж, услаж ургуулж байна. Модны ургалт 50 хувьтай.

Энэ жилийн хаврын "Бүх нийтээр мод тарих өдөр"-өөр улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу албан хаагчид байгууллагын хуваарьт газарт нарс, гүйлс, агч, голт бор, улиас, хайлаас, далан хальс зэрэг 8 төрлийн 14 ширхэг модыг тогоолж, шинээр тариалж Долоо хоног бүрийн Даваа, Мягмар гарагт усалж, арчлан хамгаалж ургуулсан ургалт 95 хувьтай.

"Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас 2024 онд зарлагдсан тендерийн дагуу "Их Хайрханы хаялага" компани гүйцэтгэгчээр шалгарч, нийт 40 га талбайд агро ойжуулалтын ажлыг хийлээ. Аймгийн төвөөс 5 км зайд улсын чанартай авто зам дагуу 9-12 эгнээ хамгаалалтын зурваст улиас, хайлаас, шар хуайс, бургас мод 19000 ширхгийг, гол талбайд жимсний плантацид чацаргана, тэхийг шээг, голт бор, ерөл, гүйлс, монос, далан хальс зэрэг мод 8000 нийт 27000 ширхэг мод тарьсан байна.

ХОЁР. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Нэг. Бодлого, зорилтот арга хэмжээний талаар

Мал аж ахуй болон хөдөө аж ахуйн салбарт 2024 онд дэвшүүлсэн засгийн газрын зарим чиг үүргийг хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын гэрээ, аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын байгуулсан гэрээнд тусгагдсан зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахад аймаг, сум орон нутгийн болон чиг үүргийн бусад байгуулагуудтай хамтран ажиллаж байна.



2023 оны жилийн эцэст 3,6 сая толгой мал тоолуулсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад адуу 11 576(6.3%), үхэр 10 985(14.7%), хонь 35 731(2.1%), тэмээ 2 570(6.2%)-аар өсч, ямаа 26 117(1,6%) буурсан байна.

Мөн нийт малын сүрэгт эзлэх хувиар нь авч үзвэл хонь 48.1 хувь, ямаа 43.1 хувь, адуу 5.3 хувь, үхэр 2.3 хувь, тэмээ 1.2 хувийг эзэлж байна.

Мөн 7347 малчин өрх тоологдсон нь сүүлийн Сүүлийн 3-н жилийн үзүүлэлтээр малчин өрхийн тоо 323 өрх буюу 9,5 хувиар буурсан байна.



Том малын зүй бусын хорогдол 298727 буюу нийт малын 8,7 хувь нь хорогдсон. Мөн оны эхний хээлтэгч, хээлтүүлэгч мал 113394 мал хорогдсноос нийт хээлтэгч малын 6,6 хувь, хээлтүүлэгч малын 5,2 хувь нь тус тус хорогдсон. Мал төлөлт нийт төлөлвөл зохих хээлтэгч 1176401 малын 813009 мал буюу 69,1 хувь нь төллөж, 89873 төл хорогдож, 723136 төл бойжсон, төл бойжилт 88,9 хувьтай байна.



Том малын зүй бусын хорогдлыг өнгөрсөн онтой харьцуулахад 293832 мал хорогдсон илүү, Бойжсон төлийг өнгөрсөн онтой харьцуулахад 360160 буурсан үзүүлэлттэй байна

Хоёр. Мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл зохион байгуулалт

2024-2025 оны өвөл, хавар ймгийн хэмжээнд 2024-2025 онд 7347 малчин өрх, 1474 мал бүхий өрхийн 3,4 сая толгой буюу хонин толгойд шилжүүлснээр 4,7 сая толгой мал өвөлжиж, хаваржихаар бэлтгэл хангагдсан. Үүнээс гадны аймаг, сумдад 53 өрхийн 33850 толгой мал, өөрийн аймгийн өөр сумдад 23 өрхийн 18551 толгой мал тус тус отор нүүдлээр өвөлжиж байна.

Мөн Аймаг дундын отрын бүс нутаг Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаанд Адаацаг, Гурвансайхан, Цагаандэлгэр сумдын 8 өрхийн 9397 толгой мал, Говьсүмбэр аймгийн

Малахын тал отрын бүс нутагт Адаацаг, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдын 8 малчин өрхийн 10472 толгой мал оторлуулахаар тус тус захиалга хүргүүлэн гэрээ байгуулсан.

Аймаг, сумдын аюулгүй нөөцөд өвс 740,0 тн, тэжээл 303,3 тн бэлтгэсэн бөгөөд өвс тэжээлийн бэлтгэл хангалт 76,5 хувьтай байна.

Өвс, тэжээлийн аюулгүй нөөц бүрдүүлэлт

2024-2025 өвөлжилтийн бэлтгэл хангахтай холбоотойгоор шаардагдах судалгаа тайлан ирүүлэх, аюулгүй нөөц хадлан гар тэжээл нэмэгдүүлэх, ажил эрчимжүүлэх зорилгоор сумдад 3 албан бичиг, зөвлөмжийн хамт хүргүүлэн ажилласан.

2024-2025 оны мал аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангалт 89 хувьтайгаар хангагдсан.

Гурав. Бэлчээр усжуулалт, тэжээлийн ургамал тариалалт

Улсын төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, малчдын хувь хөрөнгө нийт 1.004.200,0 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг, Баянжаргалан, Гурвансайхан, Дэлгэрхангай, Өлзийт, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд, Луус, Эрдэнэдалай, Баянжаргалан, Дэлгэрцогт сумдуудад нийт инженерийн хийцтэй гүн өрмийн 18 худаг, 28 цооног, 29 энгийн уурхайн худаг сэргээсэн засварлаж 61500 га бэлчээрийн талбайг усжуулж, бэлчээр усжуулалтыг өмнөх оноос 0,9%-иар нэмэгдүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр "Ус амьдрал" ХХК-тай гэрээ байгуулж, газар доорх усны геофизикийн хайгуулын судалгааг 14 сумын 36 цэгт 2024 оны 04 дүгээр сарын 10-наас 05 дугаар сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэн ажилласан.

Шинээр гаргасан болон сэргээн засварласан худаг

Аймгийн Засаг даргын 2024 оны "Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг урьдчилан бэлтгэх тухай" А/330 захирамжийн дагуу малчдыг тэжээлийн ургамал тариалуулахаар 15 суманд 50,5тн овьёос, 17,5тн улаан буудайн үрийг 15 суманд хуваарилан олгож Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Өндөршил, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 75 малчин, 49,7 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалж 57,2 тонн ургац хураан авсан.

Тэжээлийн ургамалын тариалалт, ургац

Бэлчээр хамгааллыг эрчимжүүлэх зорилгоор бэлчээрийн даац 1-3 дахин, олон дахин хэтрэлттэй бэлчээрийн хүрэлцээ хангамж дутагдалтай өвөлжилт, хаваржилт хүндэрч байгаатай холбоотойгоор малчид өөрсдийн хөрөнгөөр Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Луус, Эрдэнэдалай сумдын 44 малчин өрх өвөлжөө, хаваржааны дэргэд 98, 5 га талбайг хашиж хамгаалсан.

Дөрөв.Бэлчээрийн менежментийн чиглэлээр

Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн сайдын 2024 оны А/96 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/192 дугаар захирамжийн дагуу Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой Микробиологийн аргаар тэмцэх ажлыг Улсын төсвийн 190,0 сая

төгрөгийн санхүүжилтээр Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Эрдэнэдалай зэрэг 7 сумын 27 багийн 20,0 мянган га бэлчээрийн талбайд нөхөн сэргээх ажлыг хийсэн. Мөн аймгийн Засаг даргын А/654 дугаар захирамжаар энгийн механик аргаар бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготонотой Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Эрдэнэдалай 4 суманд 40,0 мянган га бэлчээрийн талбайд тэмцэх ажлыг зохион байгуулж байна. Мөн дээрх сумдад шувууны үүр 100 ширхэг, утагч багаж 8 ширхэг, үлий цөмлөгч 8 ширхэгийг хуваарилан олгосон. Нийтдээ 60 мянган га бэлчээрийн талбайд хортон мэрэгчинтэй тэмцсэн.

Бактержуулсан будаа болон энгийн механик аргаар

Эрчимжсэн мал аж ахуйн мэдээлэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг тоо, хэмжээ

Аймгийн хэмжээнд эрчимсэн аж ахуйн чиглэлээр Жаргалант сор ХХК нь тахианы аж ахуй 2021 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба үйл ажиллагаагаа өргөтгөн өдөрт 11000-12000 өндөг, жилд дундажаар 132,000 шинэ өндгөөр аймгийнхаа хэрэглэгчдийг хангаж байна.

Үржих эрдэнэ дэвжих ХХК нь Говь-Угтаал суманд 2022 оноос гахайн аж ахуй эрхэлж жилд дундажаар 5,3 тн мах зах зээлд худалдан борлуулж байна.

Түргэн өсөлттэй өндөр ашиг шимтэй суффолк үүлдрийн хуцны үрээр нутгийн монгол эм хонинд зохиомол хээлтүүлэг хийж, 400 төл хүлээн авч, 9 сартай хурга 45-50 кг амьдын жинтэй F-1 хурганы 2,1 тн махыг зах зээлд борлуулсан.



Гахайн аж ахуй



Өндөгний аж ахуй



Суффелк үүлдрийн төлөг

МАЛЫН ЧАНАР САЙЖРУУЛАХ, МАЛ ҮРЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

2023 онд аймгийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлуулснаар энэ оноос эхлэн 8 зорилтын 26 заалт бүхий мал үржлийн ажлын стратеги төлөвлөгөөг батлуулан сумдад хүргэж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай байна.

Тухайн төлөвлөгөөнд орсон болон малын үржлийн чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлаас дурдвал: Аймгийн үхэр сүргийг үе шаттайгаар сайжруулах ажлын хүрээнд

Баянжаргалан сумын ЗДТГазартай хамтран 2021 оноос Дорнод аймгийн Халх гол суманд үржүүлэгддэг махны чиглэлийн Дорнод монголын мухар улаан үүлдрийн хээлтүүлэгчийг сайжруулагчаар ашиглагдаж байна. Энэ онд гарсан төлөөс нь өсвөр 10 хээлтүүлэгч бойжуулахаар сонгон шилэн сонгох ажлыг зохион байгуулсан.

Дорнод аймгийн Халхгол сумаас 6 хээлтүүлэгчийг орон нутагт шинээр авчирч сайжруулагчаар ашиглахаар болоод байна.

Дорнод монголын мухар улаан өсвөр хээлтүүлэгч

Малын үндэсний удмын сантай хамтран Баянжаргалан сумын 20 хээлтэгчдэд Дорнод монголын мухар улаан үүлдрийн хээлтүүлэгчийн үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн.

Үхрийн зохиомол хээлтүүлэг

Сайнцагаан, Дэрэн суманд Сайнцагаан омгийн хээлтэгчид, Сайнцагаан омгийн хээлтүүлэгчээр, нутгийн монгол хонинд суффолк үүлдрийн хээлтүүлэгчээс үр авч нийт 580 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийсэн.

Хулд, Сайнцагаан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай Гурвансайхан сумдад хурга 215, ишиг 95 нийт 310 малыг битүү хөнгөлгөөний аргаар хөнгөлсөн.

Эрдэнэдалай сумын Хаяа ширгүний говийн хонины махны морфологи бүтэц, шимт чанарын судалгааг ХААИС-ийн Мал аж ахуйн биотехнологийн сургуультай хамтран шинжлүүлж байна.

Мөн тухайн хонины генетикийн шинжилгээг КОЙКЕ олон улсын байгууллагын санхүүжилтээр хөдөө аж ахуйн их сургуультай хамтран хийсэн. Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй, биотехнологийн сургууль, Япон улсын Окаяма шинжлэх ухааны их сургуулийн хамтарсан "Монгол малын генетик чадавхын биоинженерчлэл" төслийн хүрээнд Хэнтий, Дундговь, Өмнөговь аймагт үржүүлж буй үүлдэр, омгийн адууны генетик судалгааны дээж цуглуулах, галбирын судалгааг японы талын эрдэмтэдтэй хамтарсан судалгааны баг амжилттай гүйцэтгэсэн.

Адуу, хониноос дээж авч байгаа нь

Малын генетик нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.2, 11.6.3 дахь заалтууд, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/136 дугаар тушаал, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийж, генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлж, үнэлгээ хийх ажлыг 01/1083 дугаар удирдамж, аймгийн Засаг даргын 2024 оны 04 сарын 10-ны өдрийн А/205 дугаар захирамж, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2024 оны 04 сарын 24-ний өдрийн А/05 дугаар тушаал, Сайнцагаан сумын Засаг даргын 2024 оны 05 сарын 03-ны А/111 дугаар захирамж, Хулд сумын Засаг даргын 2024 оны 04 сарын 20-ны А/58 дугаар захирамж, Өндөршил сумын Засаг даргын 2024 оны 10 сарын 04-ний А/101 дугаар захирамж, Эрдэнэдалай сумын Засаг даргын 2024 оны 06 сарын 06-ны А/90 дугаар

захирамжуудын дагуу баталгаажсан омгийн болон нутгийн малд хавар, намрын үзлэг ангилалт хийж, төлөв байдлыг үнэлэх ажлыг зохион байгуулсан.

Дээрх эрхзүйн баримт бичгүүдийг үндэслэн баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалтыг Өндөршил, Хулд, Эрдэнэдалай, Сайнцагаан сумдууд ХХААХҮСайдын 2017 оны 05 дугаар сарын 25 ны өдрийн А\71 дугаар тушаалаар баталгаажсан үүлдэр омгийн малд үзлэг, ангилалт хийх журмын дагуу бог 7692, бод 5531 нийт 13223 малыг хамруулсан үүнээс 1033 хээлтүүлэгч, 12190 хээлтэгч малын үзлэг ангилалтад хамруулсан.

Малын үзлэг ангиллалтын явц

Малын үндэсний удмын сантай хамтран Сайнцагаан омгийн хуцнаас үр авахуулахаар орон нутгаас 2 хээлтүүлэгч тухайн газарт хүргүүлж үр үйлдвэрлэх ажил үргэлжилж байна.

ГУРАВ. ХҮНС, ХООЛ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ГАЗАР, ТАРИАЛАН, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР, ХОРШОО АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖИЛ

1. Хүнс, хоол үйлдвэрлэл, худалдааны салбар

Аймгийн боловсруулах үйлдвэрлэлийн салбарын 80,8 хувийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлдэг бөгөөд энэ онд 1,7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 1,9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оноос үйлдвэрлэлт 17,6 хувиар өссөн байна. Хүнсний худалдааны салбарт 47381,1 сая төгрөгний, Хоол үйлдвэрлэлийн салбарт 5229,3 сая төгрөгний борлуултын орлоготой ажилласан байна.

“Хүнсний хангамж аюулгүй байдал”-ын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд Хүнсний үйлдвэрлэлийг дэмжих “Хөрөнгө оруулалт”-ын хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар Сайнцагаан Дэлгэрхангай сумын үйлдвэрлэгч Говийн Гэгээ ХХК, Хадган-Уул ХХК-иудын зээлд хамрагдах хүсэлт ирүүлсний дагуу дэмжиж ХХААХҮЯамны ХҮБХЗГазарт хүргүүлэн ажиллалаа. Улмаар ХХАХҮЯамнаас судлаад Говийн Гэгээ ХХК-ны хүсэлт зээлд хамрагдах шалгуурт тэнцсэн учир арилжааны банкинд хүргүүлсэн боловч ХААН банк зээлийн санхүүжилт дууссан гэсэн хариу өгсөн учир санхүүгийн дэмжлэг авч чадаагүй байна.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, “Мах ангилж савлах, мах боловсруулах үйлдвэр цех байгуулах санаачилга ирүүлсэн “Мянгат алтан судар” хоршоо, “Говь наран” ХХК, “Хулд мандал” ХХК-дад 550 сая төгрөгний санхүүжилтийн дэмжлэг үзүүллээ.

Аймгийн хэмжээнд Хүнсний боловсруулах үйлдвэр-1, /талх нарийн боов, сүүн бүтээгдэхүүн, хатуу чихэр, цэвэр ус/ Талх нарийн боов, хэрчсэн гурилын -11, бууз баншны-5, цэвэр усны -3, мал төхөөрөх бойны цэг -3, өндөгний аж ахуй - нийт-24 үйлдвэр цех 80 гаруй ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж байна. Үйлдвэрлэлийн хүчин чадалаа 100 хувь ашигладаг байна.

Орон нутгийн үйлдвэрлэлээр гурилан бүтээгдэхүүн- 272,8 тонныг үйлдвэрлэж – 11хувийг, Сүү, сүүн бүтээгдэхүүн –3,1 мян.л-ийг үйлдвэрлэж -0.14 хувийг, өндөг - 84 тонныг үйлдвэрлэж 30 хувийг, Бууз, банш 20 тн мал төхөөрөх цэгт 237.5 тн мах бэлтгэж 15.5 хувийг тус тус хангаж, нийт 56,6 хувийг хангасан байна.

Мандалговь Хүнс ХХК-ны “Сүүн бүтээгдэхүүн”-ний цех нь улиралын чанартай үйл ажиллагаа явуулж байна. Тус цех нь энэ онд сүүн бүтээгдэхүүнийг шингэн сүүнд шилжүүлснээр жилд 3,0 мян.л сүүг үйлдвэрийн аргаар боловсруулж ингэний хоормог 0, мян.л, хорхой ааруул 0,3 тн-ыг тус тус үйлдвэрлэж эрүүл ахуй, чанар стандартын шаардлагад нийцсэн сав баглаа боодолтой хүн амын хэрэгцээнд нийлүүлж байна.

Хүнсний нөөцийн мэдээг 7 хоног бүрийн 1 дэх өдөр сум бүр ХХААХҮЯамны цахим системээр өгч хэвшээд байна. 11 дүгээр сарын 18-ны өдрийн мэдээгээр Аймгийн хэмжээнд хүнсний худалдаа эрхлэгчдийн худалдааны нөөцөд гурил-110,2тн, гурилан бүтээгдэхүүн-16,6тн, төрөл бүрийн будаа-51,1тн, хуурай сүү-9,2тн, өндөг-4,9тн, ургамлын тос-12,5 тн, төмс-71,1тн, хүнсний ногоо-27,6тн, элсэн чихэр-27,9тн, давс-14,4тн, савласан ус-32,9тн нөөцтэй байна.

Аймгийн хэмжээнд 15 сумын 6 хоршоо, 13 ААН, 172 иргэн нийт 24,8 га-д төмс тариалж 225тн-ыг, хүнсний ногоо 25,7 га-д тариалж 218.7 тн-ыг жимс, жимсгэнэ 16 га-д 4,6тн-ыг тус тус хураан авсан байна.

Хөнгөлөлттэй зээлийн үр дүнд хяналт хийсэн талаар:

Улсын их хурлын 2022 оны Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэжээний тухай 36 дугаар тогтоолын хүрээнд “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын зээлийг арилжааны банкаар дамжуулан 2023 онд Хүнсний боловсруулах үйлдвэрт эргэлтийн болон хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлд хамрагдсан тус аймгийн Сайнцагаан сумын Мандалговь Хүнс ХХК-ын үйл ажиллагаанд 2024 оны 5-р сарын 24-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй газрын даргаар батлуулсан “Хөнгөлөлттэй зээлийн үр дүнд хяналт тавих удирдамж”-ийн дагуу 6-р сарын 18-ны өдөр дээрх ААНэгж дээр ажиллалаа.

Хяналт шалгалтаар удирдамжийн 3.1-д хөнгөлөлттэй зээлд хамрагдсан санхүүжилтийн хэмжээ, зээлийн зориулалт, ангилал: Хаан банкны 5-р сарын 25-ний өдрийн хурлын шийдвэрээр Мандалговь Хүнс ХХК нь 2023 оны 5 сарын 31-нд хөрөнгө оруулалтын 5.2.4 болон Эргэлтийн хөрөнгийн зээлийн 5.7.3.1-д тусгагдсан заалтыг хэрэгжүүлэхээр хөнгөлөлттэй зээл авах эрх үүсч улмаар хөрөнгө оруулалтын 242 380 000 сая төгрөгийн, Эргэлтийн хөрөнгийн 104120000 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгт тус тус хамрагдсан байна.

Зээлийг зориулалтын дагуу зарцуулсан байдал, холбогдох бичиг баримттай танилцах

Тус үйлдвэр нь хөрөнгө оруулалтын зээл болох 242 380 000 төгрөгөөр үйлдвэрлэлийн хүчин чадалыг 2 дахин нэмэгдүүлж дараах тоног төхөөрөмжүүдийг худалдан авсан талаарх баримтуудтай танилцсан.

| № | Үйлдвэр цехийн нэр | Тоног төхөөрөмжийн нэр | Нэг бүрийн үнэ /төг/ | Нийт үнэ | Тайлбар | |
|----|--|---|----------------------------|------------------------|----------|--------|
| 1 | Нарийн боовны цех | Хэвийн боов чаналгын тогоо | 28 000 000 | 28 000 000 | Монгол | |
| 2 | | Боорцог чаналгын тогоо өргөгчтэй | 22 000 000 | 22 000 000 | Монгол | |
| 3 | | Талх зүсэгч PMBS-1500 | 44 128636 | 44 128636 | БНТУ | |
| 4 | | Уур гагргач Хөөлгөгч төхөөрөмж | | | | |
| 5 | | Усны температур тохируулагч /холигч/ дазотоар | | | | |
| 6 | | | Босгох шкап | 4 026 000 | 4 026000 | Монгол |
| 7 | | | Гурил элдэгч хэрчигч | 1450 000 | 1450 000 | БНХАУ |
| 7 | Цэвэр усны цехэд | Олон үйлдэлт ус цэвэршүүлэх төхөөрөмж АКРО-TW-025 загварын 250 IPH-RO систем | 25 000 000 | 25 000 000 | БНХАУ | |
| 8 | Үйлдвэрийн нэрийн барааны 2 дэлгүүрт | Халаалт дулааны Каракин 10ТПВ 3 загварын тогоо-2 | 1 950 000 | 3 900 000 | ОХУ | |
| 9 | Үйлдвэрийн гадаах камер Н.265 | Э/К -16 ш | 135000 | 2160000 | БНХАУ | |
| | | Д/К-1ш | 185000 | 185000 | | |
| 10 | | Хүлээн авагч -1ш | 315000 | 315000 | | |
| 11 | Борлуулалтын алба | Автомашин /50- 36 ДУА/ | 23000000 | 23000000 | БНСУ | |
| | Нийт дүн | | | 154 164 636 | | |

Нийт 154 164 636 төгрөгний үнэ бүхий тоног төхөөрөмжийг хөрөнгө оруулалтын зээлээр авч компанийн үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна. /баримтийг зургаар орууллаа/

Тоног төхөөрөмжийг шинэчилснээр, хүчин чадал, бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2 дахин нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн бүртгэл болон тоног төхөөрөмжийг баталгаажуулан зургаар орууллаа.

Жич дээр дурдаснаас гадна үйлдвэрийн цех тасалгаануудын агааржуулагчийн системийг шинэчилэхээр төлөвлөн ажиллаж байна.

Япон улсын санхүүжилтээр Жайка олон улсын байгууллагын хэрэгжүүлж буй ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих төслийн хүрээнд Нийслэл Өвөрхангай Дундговь аймгуудын сургуулиудад хэрэгжиж байгаа төслийн үр дүнгийн талаар туршлага солилцох хөтөлбөрийг зохион байгууллаа.

Дээрх “Туршлага солилцох хөтөлбөрөөр сургуулиуд өөрсдийн хэрэгжүүлж буй үдийн хоолны танилцуулгыг хийж, хөтөлбөрийн үр шим, гарч буй үр дүн, цаашид хүнсний хангамжийг орон нутгийн үйлдвэрлэлээр хэрхэн хангах талаар сургалт хэлэлцүүлэг хийсэн.

Тус үйл ажиллагаанд Жайка олон улсын байгууллагын төслийн баг, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яам, Боловсролын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Дундговь аймгийн Засаг даргын орлогч М.Анхбаяр, нийслэлийн болон Дундговь, Өвөрхангай аймгуудын Боловсрол, шинжлэх ухааны газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар, төсөл хэрэгжиж буй сургуулиудын захирал, хоол зүйч, тогооч зэрэг 60 гаруй төлөөлөгчид оролцсон.Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар,

Стандарт хэмжил зүйн хэлтэс, Аймгийн Тогоочдын холбоотой хамтран хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын ажилчдыг чадавхжуулах сургалтын хэрэгцэгцээг тодорхойлох зорилгоор 7 Ресторан, Зоогийн газар, кафе, цайны газруудын ажлын байранд ажиглалт хийж зөвлөгөө өгч, дүгнэлт гаргасны үндсэн дээр Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавигдах шаардлага MNS4946:2019 стандартыг мөрдүүлэх,Тогооч болон зөөгч барменыг чадавхжуулж зөв дадал хэвшлийг бий болгох үүднээс “Чадамжийн хөтөлбөр II” төсөлийг боловсруулсан. Дээрх “Чадамжийн хөтөлбөр II” сургалт, дадлагын ажлыг 10 сарын 14-өөс элүүлэн 5 байгууллагын 50 тогооч, туслах ажилчид хамрагдаж байна.

Аймгийн Үдийн хоолны зөвлөл, Боловсролын шинжлэх ухааны газар,Жайка олон улсын байгууллагын “Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих төсөл”-ийн хүрээнд ур чадварын уралдааныг зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн нас, бие бялдрын онцлог, өсөлт хөгжилтөд тохирсон шим тэжээллэг хоол бэлтгэн нийлүүлэх, тогооч

нарын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох зорилгоор “Хүүхдийн шим тэжээлт хоол” хоёрдугаар уралдааныг зохион байгуулж, Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг, Өвөрхангай аймаг, Дундговь аймгийн нийт 48 тогооч өрсөлдлөө. Өгөгдсөн материалаар үндсэн хоол, шөл, зууш, ундаа бэлтгэх тус тэмцээнд ур чадвараараа тэргүүлэн дараах тогооч нар шалгарсан. Тэмцээний тэргүүн байрт Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны тогооч Н.Ганцэцэг, Дэд байрт Сайнцагаан сумын Мандал сургуулийн үдийн хоолны тогооч Д.Алтансүх, Гутгаар байрт Луус сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын тогооч Н.Ганчимэг Тусгай байр Говийн ирээдүй цогцолбор сургуулийн дотуур байрын тогооч О.Жавзмаа, Эрдмийн далай сургуулийн үдийн хоолны тогооч Э.Оюунцэцэг нар шалгарсанбайна. Тэмцээний ерөнхий шүүгчээр Шинжлэх Ухаан, Технологийн Их сургуулийн Үйлдвэрлэл технологийн сургуулийн багш, доктор М.Пүрэвжав, Боловсролын ерөнхий газрын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Б.Энхтайван, Дундговь аймгийн тогооч нарын “Галт билэг” холбооны гишүүн, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тэргүүлэх зэрэгтэй зөвлөх багш С. Цэцэгмаа нар ажиллав.

2. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ХОРШОО, АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

2020 оны Засгийн газрын 113-р тогтоолоор баталсан журмын дагуу төсөл хүлээн авах үйл ажиллагааг 2024 оны 01 дүгээр сарын 24-өөс 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл 30 хоногийн хугацаанд зохион байгуулж 4,6 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн 31 төслүүдийг аж ахуйн нэгжээс цахимаар хүлээн авч хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж шалгаруулах үйл ажиллагаа явуулж, шаардлага хангасан 12 ААНэгжид Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах аймгийн дэд хороогоор ил тод нээлттэй хэлэлцүүлэн шийдвэрлэн аймгийн Засаг даргын А/408 тоот захирамжаар Жижиг дунд үйлдвэрийн газраас манай аймагт энэ жил хувиарласан 1,57 тэрбум төгрөгийн санхүүжүүлэлт бүхий 1,2 – р ээлжинд санхүүжүүлэх жагсаалтыг Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх газарт хүргүүлснээр 12 аж ахуйн нэгжүүдэд ЖДҮХС-аас 1.570.000.000 төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг бүрэн олгосон. ХХААХҮ-ийн сайдын А/26 дугаар тушаалаар Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн яамны хооронд байгуулсан гэрээний дагуу “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн эх үүсвэрээс орон нутагт түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор 4,2 тэрбум төгрөгийг “Загвар хоршоо”-ны үндсэн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зориулалтаар жилийн 5%-ын хүүтэй, 5 жилийн хугацаатай, үндсэн төлбөрөөс 1 жил хүртэл чөлөөлөх нөхцөлөөр олгох зээлнээс Мянгат алтан судар хоршоо 300.000.000 төгрөгийн санхүүжилт авсан. Энэ онд нийт 13 ААНэгжид 1.870.000.000 төгрөгийн зээл олгогдсон байна.

Эдгээр аж ахуйн нэгжүүдээс УБ хотоос шилжин ирсэн Дэлгэрэх плас инженеринг ХХК нь шилжин ирж ЖДҮХСангаас Ахуй үйлчилгээний чиглэлээр 300,0 сая.төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан. Тус зээлийн дэмжлэгтэйгээр 990м2 үйлчилгээний төвийг барьж ашиглалтанд оруулаад байна. Хадгалагдсан ажлын байр – 1, Шинээр бий болсон ажлын байр – 10.

Хулд мандал ХХК Улаанбаатараас шилжин ирсэн 2 иргэн, Тэгш наран би ХХК Хэнтий аймгаас шилжин ирсэн 2 иргэн, Мянгат алтан судар хоршоо Улаанбаатар хотоос ирсэн 2 иргэн, Сэлэнгэ аймгаас шилжин ирсэн 2 иргэн нийт 8 иргэнийг тогтмол ажлын байраар хангасан байна.

Тус зээлэнд Сайнцагаан, Эрдэнэдалай, Адаацаг сумдын аж ахуйн нэгжүүд хамрагдсан. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.16 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоол батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 16.2 дахь хэсэгт заасны дагуу сангаас зээл авсан зээлдэгчийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийн ажиллалаа. Аймгийн дүнгээр 22 төслийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцан хяналт үнэлгээ хийж 22 аж ахуй нэгжийн 72.6 сая.төгрөгийн орлогыг 100900037019 /Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан/ тоот дансанд төвлөрүүлж ажилласан. Мөн 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар төгрөгийн үндсэн зээлийн үлдэгдэлтэй 1,6 тэрбум 22 зээлдэгчтэй тооцоо нийлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулах “Дундговьд үйлдвэрлэв” дэлгүүрт 14 ААНэгж, 210 иргэний 120 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн борлуулагдаж байна. Борлуулалтын орлого 310,5 сая.төгрөг. Жижиг, дунд үйлдвэр, аж ахуй эрхлэгчдийг ажлын байртай болгосноор үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлсэн. Бизнес хөгжлийн төвд 5 ААНэгж, 7 бизнес эрхлэгч үйл ажиллагаа явуулж байна. Борлуулалтын орлого 571.56 сая.төг

2024 онд нийт 882.66 сая.төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж байна.

Үсчин гоо сайхны холбоотой хамтран 100 жилийн ойтой сумд болон бусад сумдын үйлчлүүлэгч нарын хүсэлтийн дагуу явуулын ахуй үйлчилгээг үзүүлсэн. Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Дэрэн, Баянжаргалан, Дэрэн, Өлзийт, Дэлгэрцогт сумдын 205 иргэнд үйлчилгээг үзүүлсэн. Энэ онд Соёмбо салоны үсчин У.Уранчимэг, Үсчин Ө.Гэрэл-Ундрах нар мастер цолын шалгуур үзүүлэлтийг ханган шалгалтаа өгч Салон мастер артист үсчин болсон. Орон нутгийн оёдолын үйлдвэр нь УУК-д өвлийн ажлын хувцас-50 ш, зуны 100 ш ажлын хувцасыг нийлүүлж нийт 31,5 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Баянжаргалан сумын 4, Гурвансайхан сумын 2, Говь-Угтаал сумын 1, Өлзийт сумын 1 УУК нь орон нутгийн малчдаас нийт 3,5 тн мах, 200 литр сүү худалдаж авч 52,5 сая.төгрөгийн борлуулалтын орлого олсон байна. Орон нутгаас нийт 84,0 сая.төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Монгол улсын Засгийн газраас “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх, энэ хүрээнд таван их наяд төгрөгийн “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөр хэрэгжүүлэхээр болсон. Нийслэл хотноо 04 дүгээр сарын 26-27 ны өдрүүдэд аймаг, сум бүрээс малчин, хоршоологчдын 3100 төлөөлөл оролцсноос манай аймгаас сумдын хоршоо хариуцсан мэргэжилтнүүд, хоршооны дарга, менежер, гишүүд, малчдын төлөөлөл 139 хүн оролцож хүнс, ХАА, мал аж ахуйн салбар, хоршооллын асуудлаар санал,

туршлагаа солилцлоо. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Шинэ хоршоо хөдөлгөөн” арга хэмжээнд оролцож, Цаашид эдийн засгийн хөгжлийг бүсчлэх тухайн бүсүүдийн онцлог, давуу талд тулгуурлан “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг уялдуулан хэрэгжүүлэхээр болсон.

Монгол улсын Засгийн газар “Дэм дэмэндээ, дээс эрчиндээ” уриатай “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг орон даяар өрнүүлэх ажлын хүрээнд “Шинэ хоршоо” хөдөлгөөний Говийн бүсийн нээлтийн үйл ажиллагааг /2024.05.04/-ний өдөр Өмнөговь аймагт зохион байгуулсан. Зөвлөгөөний гол зорилго нь мал аж ахуйн салбарт өөрчлөлт, шинэчлэлт хийх зорилготой уг зөвлөгөөнд Дундговь аймгаас 90 малчин, тариаланчид, хоршоологчдын төлөөлөл оролцож “Шинэ хоршоо” хөдөлгөөний талаар мэдээлэл авч санал солилцсон.

Энэ үеэр “Бүсийн онцлогт тохирсон хоршооны загвар төсөл”, “Хоршооны засаглал”, Хоршооны малчин, “Малчны зээлд хамрагдах боломж” зэрэг мэдээллүүдийг хүргэж, хэлэлцүүлэг өрнүүллээ.

Хулд суманд 37, Цагаандэлгэр суманд 17, Эрдэнэдалай суманд 34, Сайнцагаан суманд 98, Адаацаг суманд 49, Баянжаргалан суманд 11, Гурвансайхан суманд 24, Дэлгэрхангай суманд 6, Луус суманд 43, Өлзийт суманд 19, Дэлгэрцогт суманд 10, Дэрэн суманд 16, Өндөршил суманд 10, Сайхан-Овоо суманд 10, Говь-Угтаал суманд 17 нийт 401 хоршоо байгуулагдсан байна. Бүх сумдад сургагч багш нар ажиллаж сургалт зохион байгуулж арга зүй удирдлагаар ханган хамтарч ажилласан.

Дэрэн, Өндөршил, Дэлгэрхангай, Сайнцагаан, Хулд суманд нийт 7 удаа болсон малчдын зөвлөгөөнд Шинэ хоршоо, ХХСан, ЖДҮХсангийн талаарх сургалт зохион байгуулсан хийсэн. Хамрагдсан иргэний тоо 260. Сумдын Хоршоо хариуцсан мэргэжилтэн нар шинээр хоршоо байгуулах хүсэлтэй малчин 2800 иргэдэд мэдээлэл өгч ажиллаж байна.

2011-2023 онд ХХСангаас нийт 699 иргэн, ААНэгжид зээл олгосон. Одоогийн байдлаар 225 зээлийн үлдэгдэлтэй иргэн байгаагаас 32 иргэн муу зээлийн түүхтэй байна. Энэ нь өнгөрсөн онд 24,23 хувь байсныг 14,22 хувь болгон бууруулан ажилласан байна.

Зээлийн батлан даалтын сангийн мэргэжилтэн М.Солонготой 2024 оны 06 сарын 03-05 -ний өдрүүдэд аймгийн төвийн Сайнцагаан сумдын Төр болон Хаан банкны захирал, эдийн засагч, зээлийн мэргэжилтнүүдтэй уулзаж “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийн үйл явцийн ерөнхий мэдээллийг хүлээн авч ажилласан.

ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЧИГЛЭЛЭЭР

Сайнцагаан сумын “Ээлтэй дулаахан номгон” хоршооны гишүүн 9 малчин, бусад сумдын суралцах сонирхолтой 10 мал бүхий иргэн нийт 19 иргэнд цахилгаан хайчаар хонь хяргах сургалтыг 5 өдөр зохион байгуулсан.

Сургалтын хугацаанд 250 хонь хяргаж 310 кг ноос бэлтгэсэн. Хяргах төхөөрөмжөөр хяргахад 1 хониноос авах ноосны хэмжээ 0,1-0,3 граммаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

“Их онь” ХХК-ний Ноос угаах үйлдвэр нь анхан шатны тордолт, ангилалтыг хийж 152 тн ноосыг угааж, зах зээлд борлуулсан.

Судалгаа хөгжлийн хүрээлэнгээс Арьс ширэн түүхий эдийн нөөц ашиглалтыг нэмэгдүүлэх, малыг эрүүлжүүлэх, нядалгааны үеийн гэмтлийг бууруулах чиглэлээр зохион байгуулсан цахим сургалтад 15 сумын ХАА-н тасгийн мэргэжилтэн болон Сайнцагаан сумын 3 мал төхөөрөх цехийн 8 ажилтанг хамруулсан. 3 мал төхөөрөх цехд MNS 0060:2013 стандартыг мөрдүүлж эхэлсэн.

Бог малын арьс хуулах төхөөрөмжийг ЭЭТМО ХХК-ийн мал төхөөрөмж цехд байршуулан 45 малын арьсыг гэмтээхгүйгээр хуулж зах, зээлд нийлүүлсэн. Ингэснээр төхөөрөмж ашиглан хуулсан арьсны тоо 61353 болсон.

Арьс, шир, ноос боловсруулах зориулалт бүхий 32*6 харьцаатай 4 өрөө ажлын байрыг ОНТөсөвт санхүүжилтийг суулган барьж байна. Энэ ажлын байр баригдсанаар “Шинэ хөдөө” төслөөр ирсэн тоног төхөөрөмжийг байршуулна. Барилгын явц 40 хувьтай.

Тус төхөөрөмжийг ашиглах гэрээг иргэн У.Энхбаяртай байгуулан ажиллаж байна.

Судалгаа хөгжлийн төв, аймгийн ХХААГ-тай хамтран 2024 оны 11 сарын 08 өдөр Эрдэнэдалай сумын ХАА-н тасгийн мэргэжилтэн болон тус төхөөрөмжийг ашиглахаар гэрээ байгуулсан У.Энхбаяр нарыг арьс, шир боловсруулах тоног төхөөрөмжийн сургалтад хамруулсан.

“NAP” төслөөс "Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх нь" сургалтаар "Баялаг төв"-өөс үйл ажиллагаагаа танилцуулж, хог хаягдлыг ангилан ялгах, эко системийн талаар сургалтыг 116 хүн зохион байгуулсан.

БОГ-тай хамтран сумдын байгаль орчны 12 мэргэжилтэн, ЕБС-ийн 79 сурагч, цэцэрлэгийн 82 хүүхдэд, Эх дэлхийн цаг арга хэмжээгээр 45 хүүхдэд, Дэлгэрцогт сумын 30 иргэн, 35 сурагчид, Ахмадын хорооны 80 ахмад, Эрдэнэдалай суманд 52 сурагч, солонгос хэл сургалтын 30 оюутан залуучуудад хог хаягдал, хог хаягдлаа ангилан ялгах тухай сургалт зохион байгуулсан.

Экосум ТТБ-тай хамтран 15 сумын 100 иргэнд “Монгол улсаа хоггүй орон болгоё” хог хаягдлын сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулсан.

Дэлгэрцогт суманд хог хаягдлыг ангилан ялгах, мэргэжлийн байгууллагад дахивар тушаахад анхаарах асуудал сэдвээр сургалт зохион байгуулж 30 хүнийг хамруулсан.

Баянжаргалан Сумын 40 гаруй иргэн , сургуулийн 120 гаруй сурагчдад , уул уурхайн 12 ААН-д хог хаягдлын талаар сургалт сурталчилгаа зөвлөмж зэргийг хүргэн ажилласан.

Говь-Угтаал Иргэн айл өрх ААН-үүдэд хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах , нүхэн жорлонгийн талаарх гарын авлага тарааж мэдээлэл хүргэж дадал суулгах чиглэлээр 4 ААН, 25 өрх, давхацсан тоогоор 78 иргэнд тараах материалыг хүргэн ажиллаад байна. Танхимын сургалт хийгдээгүй болно.

Эрдэнэдалай Багийн иргэдийн нийтийн хурал болон АСА Цогцолбороор хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах, хуулийн хэрэгжилт, цаг үеийн байдал, хогийн нэгдсэн цэгийн ашиглалт зэрэг сэдвээр мэдээлэл сургалтыг хийж давхардсан тоогоор 265 иргэн хамрагдсан байна.

Нийт 6 удаагын сургалт, мэдээлэл өгсөн арга хэмжээ болж. Үүнд хамрагдсан хүний тоо 1116.

Сургууль, цэцэрлэгийн хэрэгцээнд нийлүүлж буй төрийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн эзлэх хувь 79.

Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрийн нийлүүлэлт 15,400 кг бүтээгдэхүүн буюу 800,0 сая.төгрөг байна.

Газар тариалангийн чиглэлээр: Орон нутгийн үйлдвэрлэлээр хүн амын хэрэгцээт төмс, хүнсний ногооны 22 хувийг хангасан байна.

Аймгийн хэмжээнд 15 сумын 6 хоршоо, 13 ААН, 172 иргэн нийт 91,8 га-д тариалж, үүнээс төмс 24,8 га-аас 225,3тн, хүнсний ногоо 25,7 га-аас 219тн, жимс жимсгэнэ 4,6 га-аас 4,64 , малын тэжээлийн 34,8га- 33,5 тн-ийг тус тус хураан авсан байна.

Аймгийн хэмжээнд энэ онд өвөл, зуны 154 ш хүлэмжинд буюу 19046 м2 талбайд тариалалт хийснээр хүлэмжийн тариалалт өмнөх оноос 7 ш буюу 3046 м2 талбайгаар шинээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Энэ онд хүлэмжээс 126,2 тн ургац хураан авч, урд онтой харьцуулахад 25,4 тн –оор нэмэгдсэн байна.

Өвлийн хүлэмж шинээр нэмэгдсэн байдал :1. Сайнцагаан сумын Мөнгөлөг МД ХХК өвлийн хүлэмжний зориулалтаар 2023 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 179.5 сая төгрөгний хөнгөлөлтэй зээлд хамдагдсан. Энэ онд шинээ 0,5 га талбайг хашаажуулж, шинээр $10*30=300$ м.кв хүлэмжинд хүнсний нарийн ногоо тариалж, нийт 3,2 тн өргөст хэмх хураан авсан байна.

Сайнцагаан сумын иргэн С.Амарбаясгалан Бүгд найрамдах солонгос улсын технологиор барьсан 3 улирлын $280*4=1120$ м.кв хүлэмжинд эрт ургацын байцаа, өргөст хэмхийг тариалж, нийт 16,5 тн-ийг ургац хураан авч орон нутгийн зах зээлд нийлүүлсэн.

Сайнцагаан сумын иргэн Ч.Ихбаяр нь хувийн хөрөнгө оруулалтаар 190,0 сая төгрөгөөр шинээр 3 га- талбайг хашаажуулж, Зуны 4 ш буюу $(7*50=350\text{м}^2)*4=1400\text{м}^2$ барьж байгууллаа. Дээрх хүлэмжүүдэд тарвас, лооль,

өргөст хэмхийг тариалсан. мөн 2,3 га ил буюу гадаа талбайд эрдэнэ-шиш тариалж, нийт 15,6 тн-ийг хураан авсан байна.

Сайнцагаан сумын “ Арвин их сан” ХХК нь жимс, жимсгэнэ тариалалтын зориулалтаар ЖДҮХСангийн хөнгөлөлтэй зээлд хамрагдаж 210.0 сая төгрөг авч үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна. Энэ онд 3 га талбайг хашаажуулж, шинээр 3 га талбайд алимны төгөл байгуулах зорилгоор 4 төрлийн сортын алимны суулгац тариалсан. Ургалтын 90 хувьтай ургасан байна.

"ДУНДГОВИО НОГООРУУЛЪЯ" ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАГСАН. “Дундговвио ногооруулъя” үзэсгэлэн худалдааг 5 сарын 19,20-ний өдрүүдэд Чагдаржавын төвийн гадна талбайд зохион байгууллаа. Уг үзэсгэлэн, худалдаагаар 19-р нэр төрлийн төмс, хүнсний ногооны үр,үрсэлгээг тарих, арчлах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг худалдан 3,5 сая төгрөгийн борлуулалтын хийж, газар дээр нь 150 хүнд мэргэжил арга зүйн зөвлөмжийн үйлчилгээг үзүүлж ажилласан.

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-аас хэрэгжүүлж буй Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн хоолны үйлдвэрлэлийг дэмжих” төслийн нэгжтэй хамтран Сайнцагаан сумаас сонгогдсон “Мандал”, “Говийн Ирээдүй” сургуулийн үдийн хоолны хангамжид 4 нэр төрлөөр хүнсний ногоог нийлүүлж, нийт 1тн ногоог нийлүүлсэн байна.

Үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан талаар:

“Говийн өнгө - 2024” үзэсгэлэн худалдааг энэ сарын 13-15-ны өдрүүдэд Дундговь аймгийн Мандалговь хотноо зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд Дундговь аймгийн 15 сумын болон Өмнөговь, Дархан-Уул, Сэлэнгэ, Архангай аймаг, Улаанбаатар хотын нийт 200 гаруй үйлдвэрлэл эрхлэгч оролцож, гурван өдрийн турш 374,8 сая төгрөгийн борлуулалт хийжээ. Оролцогчдыг салбараар нь ангилбал Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл – 104, Төмс, хүнсний ногоо – 19, Нийтийн хоол үйлдвэрлэл – 23, Хөнгөн, аж үйлдвэр, гар урлалын чиглэлээр – 54, бусад орон нутгаас 7 иргэн нийт 207 иргэн, ААНэгж оролцсон. Энэ нь өнгөрсөн жилийнхээс оролцогчдын тоо 2 дахин нэмэгдсэн, Борлуулалтын орлого 3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Үзэсгэлэн худалдаанд оролцогчдоос 12 төрлөөр шилдгүүдийг тордуулсан юм.

1. Шилдгийн шилдэг “Гран при” шагнал Урам кидс ХХК – Сайнцагаан сум
2. Шилдэг айраг үйлдвэрлэгч өрх-Шаравжамц Жинхүү – Сайхан-Овоо
3. Шилдэг сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч-
 - Гончигсамбуу Цэвэлмаа – Хулд
 - Чинзүрх Ариунзул – Өлзийт
4. Шилдэг газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч
 - Баатар Өсөхжаргал – Луус
 - Хулан Базарсүх – Дэлгэрхангай
5. Шилдэг аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч-Чимэдцэрэн Цогтбаяр – Сайнцагаан

6. Шилдэг гар урлал үйлдвэрлэгч- Болдбаатар Дамдинцэрэн – Сайнцагаан
7. Шилдэг хүнсний бусад нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч-Ээлт Фүүд ХХК – Сайнцагаан
8. Шинэ бүтээгдэхүүн, шинийг эрэлхийлэгч иргэн
 - Буд Мөнхжаргал – Эрдэнэдалай
9. Шилдэг хоол үйлдвэрлэгч Ундром цайр ХХК – Сайнцагаан
10. Шилдэг зохион байгуулалттай сум-Дэлгэрцогт сум
11. Шилдэг үйлдвэрлэгчтэй, хамгийн их борлуулалттай сум-Сайнцагаан сум
12. Шинэ брэндиг бий болгосон сум- Луус сум

“Дундговь түншлэл” нэртэйгээр зохион байгуулж эхэлснээс хойш 20 дахь жилдээ тасралтгүй зохион байгуулж байгаа энэхүү арга хэмжээнд идэвх, санаачилгатай оролцсон иргэд, аж ахуйн нэгжийг талархал, мөнгөн шагналаар шагналаа. Үүнд:

1. Сайнцагаан сум – Uran wool Ө.Дугармаа
2. Сайнцагаан сум – Шимт ургац хоршоо
3. Сайнцагаан сум – Хөөт булаг ХХК
4. Сайнцагаан сум – Мандалын гэгээ хот тохижуулах
5. Сайнцагаан сум – Ц.Гэрэл
6. Сайнцагаан сум – Д.Бат-Энх /ХБХХТөв/
7. Адаацаг сум – З.Ганганмаа
8. Өндөршил сум – Ч.Хишигбаяр
9. Баянжаргалан сум – Д.Байгальмаа
10. Дэрэн сум – Х.Цэвэлсүрэн
11. Гурвансайхан – М.Ариунцэнгэл нар шалгарчээ.

8 сарын 16-18ны хооронд “Нүүдэлчин” соёлын фестиваль үзэсгэлэнд Дундговь аймгаас Тэббэ ХХК болон У.Батмагнай, Г.Отгонбямба, Ц.Оюунчимэг, Ж.Сарнай, Д.Мөнхжаргал, Д.Гэрэл, Д.Цэрмаа нар амжилттай оролцож 9,7 сая.төгрөгийн борлуулалт хийсэн.

8 сарын 16-18ны хооронд “Нүүдэлчин” соёлын фестиваль үзэсгэлэнд Дундговь аймгаас Тэббэ ХХК болон У.Батмагнай, Г.Отгонбямба, Ц.Оюунчимэг, Ж.Сарнай, Д.Мөнхжаргал, Д.Гэрэл, Д.Цэрмаа нар амжилттай оролцож 9,7 сая.төгрөгийн борлуулалт хийсэн.

2024 оны 09 дүгээр сарын 23-29-ний өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнд ХХААХҮЯамнаас жил бүр зохион байгуулдаг “НАМРЫН НОГООН ӨДРҮҮД 2024” үзэсгэлэн худалдаанд Сайнцагаан сумын өрхийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн Цэцэгмаа, Дэлгэрцогт сумын иргэн С.Цэцэгмаа, Д.Буян-Орших, Д.Мөнхжаргал даришлсан хөмүүл, цагаан идээ, Эрдэнэдалай сумын иргэн Ш.Бөндөгхорол ноосон бүтээгдэхүүний чиглэлээр амжилттай оролцож 5,7 сая.төгрөгийн борлуулалт хийсэн.

ДӨРӨВ. ХЯНАЛТЫН САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Хүнсний хяналтын хэлтэс нь 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилго, 6 зорилт, 16 арга хэмжээг төлөвлөн Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Малын генетик нөөцийн тухай, Улсын нөөцийн тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулиуд, Засгийн газрын хяналт шалгалтын төлөвлөгөө, Хүнс хөдөө аж ахуйн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго, зорилтыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн хүнсний аюулгүй байдлыг хангуулах, иргэдэд аюулгүй хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, зорилтын хүрээнд хийгдэх ажлуудыг алба, улсын байцаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллалаа.

Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалт хийх.

Хүнс, хөдөө аж ахуйн хяналтаар урьдчилан сэргийлэх нийт 8 арга хэмжээг зохион байгуулсан. Шалгалтаар нийт 277 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийгдэж, нийт 465 дутагдал илрүүлж, 314 буюу 67,5%-ийг тухайн газар дээр нь арилгуулж, 124 заалттай 18 улсын байцаагчийн албан шаардлага өгч ажилласан. Зөрчил арилгалтын хувь 94,1%-тай байна.

1. Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам, Боловсролын яам, Эрүүл мэндийн яамны хамтарсан 03/00/13 дугаартай удирдамжийн хүрээнд Дундговь аймгийн төв, Луус, Хулд, Дэрэн, Дэлгэрцогт сумдын ЕБС, СӨБ-ын байгууллгын 48% буюу нийт 12 цэцэрлэг, 8 сургуулийн 2024-2025 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлын урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хяналт шалгалтад хамруулсан. Хяналт шалгалтаар нийт 112 дутагдал илрүүлж, 24 буюу 21 хувийг газар дээр нь арилгуулж, 12 газарт 88 заалт бүхий хамтарсан албан шаардлага хүргүүлж ажиллаа. Хяналт шалгалтыг холбогдох хяналтын хуудсаар эрсдэлийн үнэлгээ хийхэд нийт хяналт шалгалтад хамрагдсан газруудын 20 хувь нь дунд, 80 хувь нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Нийт дунджаар эрсдэл үүсэх магадлал 21,3 бага эрсдэлтэй, хууль сахин мөрдөлтийн хувь дунджаар 79,5 хувьтай байна. Хулд сумын сургуулийн барилга байгууламжийн хана, таазны шохой хуучирч муудсан, хоол үйлдвэрлэлийн гал тогоо нь стандартын шаардлага хангахгүй, тоног төхөөрөмжөөр хангалтгүй, засвар үйлчилгээ хийх шаардлагатай тул 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт шаардлагатай хөрөнгийн санал оруулах талаар Хулд сумын Засаг даргын тамгын газарт албан тоот хүргүүлсэн. Сайнцагаан сумын ерөнхий боловсролын Мандал сургууль нь удаа дараа Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийг зөрчин төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн барилга байгууламж дахь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын байр, талбайг түрээсэлсэн, мөн тус түрээсийн өрөө тасалгаанд сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүн худалдаалсан тул аймгийн Боловсролын газарт тус сургуулийн захирал, бусад холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл оногдуулах тухай хугацаатай албан бичиг өгсөн.

Үр дүн: Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилгалтын хувь 92%, улсын байцаагчийн өгсөн албан шаардлагын хэрэгжилт 88,7%-тай байна.

2. Өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангалтын урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар аймгийн сумдын аюулгүй нөөц бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, хадгалалтын нөхцөл шаардлага хангах эсэхийг газар дээр нь үзэж, стандартын шаардлага хангуулах тухай заавар зөвлөгөөг өгч ажилласан. Чанар аюулгүй байдлыг нь нотлох дагалдах гарал үүслийн тодорхойлолтгүй бүтээгдэхүүн авчирсан 1 иргэнд улсын байцаагчийн албан шаардлага өгч зөрчлийг арилгуулан. Мөн 2 сумын аюулгүй нөөцийн хадгалалтанд байгаа өвс тэжээлийг лабораторийн шинжилгээнд хамруулж чанар аюулгүй байдалд үнэлэлт дүгнэлтийг өгч ажилласан.

Үр дүн: Хяналт шалгалтаар аймгийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангалтын байдлыг Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоолын хэрэгжилтийг бэлчээр, худаг, ус, хашаа хороо, оторлолт, өрх хүн ам, малын тоог оролцуулан дүгнэхэд 89%-тай байна.

Дундговь аймгаас 2024 оныг “Хүүхэд гэр бүр, хөгжил хамгааллын жил” болгон зарласантай холбогдуулан байгууллагын албан хаагчид болон, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургалт зохион байгуулах

1. Байгууллагын 17 албан хаагчдад “Сахар хүний биед үзүүлэх сөрөг нөлөөлөл” сэдвээр сургалт зохион байгуулсан.

2. Хүүхэд хамгаалал, болзошгүй эрсдэлээс хамгаалах, аюулыг илрүүлэх, арилгах ажлын хүрээнд ХХААГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр баталсан удирдамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг сургуулийн орчны 3 худалдааны газар, нарийн боов, сүү, бууз, баншны 3 цехийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 2 худалдааны газраас хадгалалтын хугацаа дууссан 149 ширхэг бохь, 9 ширхэг шоколад илэрснийг тухайн газар дээр нь устгуулж, 2 төрлийн хаяг, шошгын зөрчилтэй бүтээгдэхүүнийг лангуун дээрээс татан авахуулсан. Стандартын шаардлага хангаагүй орчинд үйл ажиллагаа явуулсан нарийн боовны 1 цехийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоож ажилласан. Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнээр зөвлөмж бэлтгэж, байгууллагын вэйб сайтад байршуулж, иргэдэд хүргэн ажилласан байна. Аймгийн төвийн Ерөнхий боловсролын 4 сургуулийн 3-6 дугаар ангийн 87 сурагчдад “Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүн”, “Хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгыг хэрхэн унших”, “Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах сахар, давс, өөх тосны агууламж, Хүний өдөрт авах илчлэг, сахар, давс, өөх тосны хэмжээ”, Худалдааны газруудын хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах горимын талаар сургалт зохион байгуулсан.

Хүнсний худалдааны чиглэлээр хяналт шалгалтын мэдээ, зөвлөмжийн 7 удаа, хүнсний үйлдвэр, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр зөвлөмж, гарын авлага 4 удаа, мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний хяналтаар хяналт шалгалт, сэрэмжлүүлэг, сургалт, видео хичээл зэрэг 13, нийт 24 мэдээллийг байгууллагын мэдээллийн самбар болон вэйб сайтаар тус тус иргэдэд ил тод мэдээлсэн байна. Ил тод байдлын үнэлгээний хувь 98%-тай байна.

1. Хүнсний худалдааны чиглэлээр 1.Цагаан сар, 2.Хүүхдийн баяр, 3. Наадмаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн тухай танилцуулга 4.Төлөвлөгөт хяналт шалгалт, 5.Бэлтгэсэн гарын авлага зөвлөмж, Хүнсний худалдаа, үйлдвэр, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр зөвлөмжүүд 6.Дотоодын үйлдвэрлэлийн нөөшилсэн хүнсний бүтээгдэхүүнд хийсэн хяналт шалгалт, 7. Ёс зүйн тайланг хяналтын албаны

болон бусад мэдээллийн самбарт байршуулсан. 2. Хүнсний үйлдвэр, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр байгууллагын мэдээллын самбарт 4 удаа иргэн ААН-д зориулсан зөвлөмж гарын авлага байршуулж, мөн байгууллагын вэб сайтад сургуулийн орчинд худалдаалхыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнээр 6 зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг бэлтгэж байршуулсан. 3. Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний хяналтаар фэйс бүүкийн группэд ногоон тэжээл тариалах, ногоон ургамал даршлах тухай 2 видео хичээл байршуулж олон нийтэд түгээж, байршуулвал зохих 13 мэдээллийг иргэдэд ил тод мэдээлсэн. Нийт 24 мэдээллийг байршуулсан байна.

2. Төрийн байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээг цахимжуулж, “E-Mongolia” төрийн үйлчилгээний нэгдсэн системээр үзүүлдэг болох арга хэмжээний дагуу урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар шинээр эрхлэгч 2, мэдээлэл өөрчлөгдсөн 18 газар нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэх igov.mn программд өөрчлөлт орсон мэдээллээ бүртгүүлээгүй байсныг бүртгэлийг шинэчлэн өөрчилж бүртгэсэн. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нарт цахим системд хэрхэн нэвтрэх, яаж бүртгүүлэх талаар гарын авлага бэлтгэж тараасан.

3. Малчдад баталгаажсан үүлдэр омгийн мал, түүнийг өсгөн үржүүлэхийн ач холбогдол, холбогдох стандарт, дүрэм журмыг сурталчилан таниулах ажлын хүрээнд Дэрэн, Говь-Угтаал, Дэлгэрхангай сумдын 370 гаруй малчдад 3 удаа сургалтыг зохион байгуулж мэдлэг мэдээллийг нэмэгдүүлсэн. Сургалтанд 40 хүн хамруулах байсан 370 гаруй хүн хамрагдсан.

Хүнсний сүлжээний бүх үе шатанд эрсдэлээс урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах замаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулна.

Хүнсний худалдааны 15, хоол үйлдвэрлэлийн 8 газар, 4 хүнсний үйлдвэр, мал үржүүлэг технологийн үйл ажиллагааны хяналтын чиглэлээр 9 нийт 36 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. 4 объектын үйл ажиллагаа зогссон. Шалгалтаар нийт 343 дутагдал илрүүлж, 96,7%-ийг арилгуулж, 36 газрын эрсдлийг бууруулж ажилласан байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалт

Төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн 40 объектоос хүнсний худалдааны 15, хоол үйлдвэрлэлийн 8 газар, 4 хүнсний үйлдвэр, мал үржүүлэг технологийн үйл ажиллагааны хяналтын чиглэлээр 9, нийт 36 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. 4 объектын үйл ажиллагаа зогссон. Шалгалтаар нийт 343 дутагдал илрүүлж, 30,6% буюу 105 дутагдлыг тухайн газар дээр нь арилгуулсан. Бусад илэрсэн дутагдлыг арилгуулахаар 238 заалттай улсын байцаагчийн 29 албан шаардлага өгч ажилласан. Албан шаардалгын хэрэгжилт 95,8% байна. Хяналт шалгалтаар дотоод хяналт шалгалт хэрэгжүүлж ажиллаагүй, улсын байцаагчийн албан шаардлага биелүүлж ажиллаагүй 1 иргэн, 1 аж ахуй нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу 600000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Үр дүн: Хяналт шалгалтад хамрагдсан 36 объект эрсдэл буурсан байна. Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар албан шаардалгын хэрэгжилт 95,8%-тай байна.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалт

1. Төрийн нарийн бичгийн даргаас өгсөн чиглэл, 2 байгууллагаас ирүүлсэн 3 хүсэлтийн дагуу 4 төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 100% хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар 5 зөрчил илрүүлж 1 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч 82%-ийг арилгуулан, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, хадгалалтын нөхцөл нь стандартын шаардлага хангаж буй эсэхэд 4 дүгнэлт гаргаж өгч ажилласан.

2. Хүнс, Хоол үйлдвэрлэл үйлчилгээтэй холбоотой нийт 3 гомдол мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж нийт 25 дутагдал илрүүлж, 5 дутагдал буюу 25 хувийг газар дээр нь арилгуулж улсын байцаагчийн хугацаатай 2 албан шаардлагад 20 заалтыг тусган өгч, Зөрчлийн тухай хуулийн дагуу 2 аж ахуй нэгжид тус бүр 1000000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, гомдол гаргасан иргэдэд мэдэгдэж ажилласан. Торгуулийг бүрэн барагдуулсан. Илэрсэн зөрчлийг арилгуулхаар 2024.03.21 өдрийн 08-23-02/030/02 дугаартай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагын хариу ирүүлээгүй хэрэгжилт хангалтгүй, илэрсэн зөрчил арилаагүй тул 2024.05.22 өдрийн 08-23-02/030/01 дугаартай акт үйлдэж Тэгш наран би ХХК-ийн үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээ авсан. Зөрчил арилгуулалт 100%-тай байна.

3. Нийт 8 сумын 61 аж ахуйн нэгжүүдээс ирсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтын явцад 8.11.2 кодтой хяналтын хуудсаар эрсдлийн үнэлгээ хийж, давхардсан тоогоор нийт 175 дутагдал илрүүлж, 82% буюу 137 дутагдлыг тухайн объект дээр нь арилгуулсан. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл авах, сунгуулахад улсын байцаагчийн дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 49 хүсэлтийг 100% шийдвэрлэсэн.

Үр дүн: Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар нийт зөрчил арилгалтын хувь 88%-тай байна.

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт

1. Нийтийг хамарсан баяр ёслол, цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй цагаан сар, хүүхдийн баяр, наадмын 3 арга хэмжээнд Худалдаа, Хүнс, хоол үйлдвэрлэлийн нийт давхардсан тоогоор 206 газрыг хамруулан урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж нийт 282 дутагдал илрүүлж үүнээс 244 буюу 86,5 хувийг газар дээр нь арилгуулж 24 заалттай улсын байцаагчийн хугацаатай 4 албан шаардлага, 57 заалттай улсын байцаагчийн 3 зөвлөмж, 46 иргэнд иргэдэд зориулсан зөвлөмж гарын авлага тарааж ажилласан. Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилгалт 100% байна. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар өгсөн зөвлөгөө, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт 97%-тай, хоол хүнсээр дамжих өвчин, хоолны хордлогот халдвар гараагүй байна.

Үр дүн: Хоол хүнснээс шалтгаалсан хордлогот халдвар гараагүй байна.

2. Гадаад болон төр засгийн тэргүүн, тусгай хамгаалалтад байхаар заагдсан албан тушаалтны ажлын айлчлалын үеийн хоол хүнсний аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх удирдамжийн хүрээнд 2024 онд Дундговь аймагт

гадаад орны болон төр засгийн тэргүүн, тусгай хамгаалалт бүхий этгээд, зочин төлөөлөгчийн 3 удаагийн айлчлал ирсэн. Үүнд Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ ажлын айлчлалаар ирсэн. 2024.07.12,14-ны өдөр Бутаны Хаант улсын Цог Жавхлант Хаан Жигмэ Гэсэр Намжил Ванчук, Цог Жавхлант Хатан Жэцүн Пэма Ванчук нар 3 хүүхдийн хамт, 2024.08.24,26-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Словени Улсын ерөнхийлөгч Наташа Мусар нар Дундговь аймгийн төвд байрлах “Дэлгэрэх бүрд” ресторанд үдийн зоог барьж, Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт байрлах “Цагаан суварга” Говь каравансерэй жуулчны баазд өдрийн зоог барьсан. Дэлгэрэх бүрд ХХК-ийн ресторан, Говь каравансерэй жуулчны баазын ресторанд давхардсан тоогоор 5 удаа урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтаар бүтээгдэхүүн түүхий эдийн гарал үүсэл шинжилгээний бичгийг бүрэн бүрдүүлээгүй, тухайн өдөр бэлтгэсэн хоолны дээжийг зохих хэмд хадгалаагүй зөрчил илэрч газар дээр нь арилгуулж ажилласан. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын явцад нийт 8 хүнсний бүтээгдэхүүн, 2 ундны уснаас дээж авч аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн лабораторт эрүүл ахуй, нян судлалын хяналтаар нийт 49 үзүүлэлтээр шинжилгээнд хамруулсан. Шинжилгээгээр эерэг сорьц илрээгүй. Зөрчил арилгалт 100%-тай.

3. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд аймгийн “Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг 8.10.2 кодтой нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудсаар шалгаж эрсдэлийг үнэлэхэд “Бүрдийн уянга” хүүхдийн зуслангийн хоол үйлдвэрлэл нь 17,7 хувийн бага эрсдэлтэй үнэлэгдэж, хууль сахин мөрдөлтийн хувь 87,5 хувьтай байна. Хүүхдийн зуслангийн ажилчдад хоолны хордлого, хордлогот халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж ажиллах талаар зөвлөмж өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулхаар улсын байцаагчийн зөвлөмжид 5 заалтыг тусган өгсөн.

4. Дотоодын үйлдвэрийн нөөшилсөн, даршилсан бүтээгдэхүүний худалдаалалт, чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийхэд Дундговь аймагт нөөшилсөн, даршилсан бүтээгдэхүүний үйлдвэр байхгүй бөгөөд шалгалтад Улаанбаатар хотоос дотоодын үйлдвэрийн нөөшилсөн, даршилсан бүтээгдэхүүний татан авч худалдан борлуулж буй Сайнцагаан сумын 13 аж ахуй нэгж, 2 иргэн, Дэрэн сумын 6 аж ахуй нэгж, 2 иргэн нийт 23 худалдааны газруудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтын явцад илэрсэн 12 дутагдалыг тухайн газар дээр нь 100% арилгуулсан. Шалгалтын явцад дотоод хяналт шалгалтыг тогтмол хийх, ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтөлгөөг бүрэн хөтлөж хэвших, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, дүрэм журам, шинэчлэгдсэн стандартуудыг судлах талаар 23 газрын 92 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

5. Аймгийн хэмжээнд хиам, нөөшилсөн махан бүтээгдэхүүн, бууз баншны үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх /махан бүтээгдэхүүний давс, тослог, илчлэгийн хэмжээ, хүнсний нэмэлтийн агууламжид тандалт судалгаа хийх/ удирдамжийн дагуу хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэгч буюу 2 бууз баншны цехын үйл ажиллагаа, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний давс, тослог, илчлэг, хүнсний нэмэлт хэрэглэдэг эсэхэд тандалт судалгаа хийлээ. 2 газраас 3 нэр төрлийн бүтээгдэхүүнээс 500гр

савлагаатай 3ш дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамруулсан. Шинжилгээгээр бүтээгдэхүүний илчлэг шошгон дээрх мэдээлэлтэй зөрж байсан тул улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгч зөрчлийг арилгуулсан. Хяналт шалгалтад хамрагдсан 2 газар нь хүнсний нэмэлт хэрэглээгүй байна.

Баталгаажуулах үйл ажиллагаа

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-02/15 дугаартай удирдамжийн хүрээнд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5².1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15¹.1.3 дахь хэсэг, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд болон холбогдох стандарт, журам, дүрмийн хэрэгжилтийн байдалд нийт 8 сумын 61 аж ахуйн нэгжүүдээс ирсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтын явцад 8.11.2 кодтой хяналтын хуудсаар эрсдлийн үнэлгээ хийж, давхардсан тоогоор нийт 175 дутагдал илрүүлж, 82% буюу 137 дутагдлыг тухайн объект дээр нь арилгуулсан. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл авах, сунгуулахад улсын байцаагчийн дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 49 хүсэлтийг 100% шийдвэрлэсэн.

Үр дүн: Шаардлага хангаагүй аж ахуй нэгж гараагүй байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН А/812 ТООТ ЗАХИРАМЖ “ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭСЭН САРЫН АЯНЫ” ХҮРЭЭНД ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРААС ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ

Аймгийн Засаг даргын 2024 оны 11 сарын 14 өдрийн А/812 тоот захирамжийн дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын газрын дарга удирдамж гаргаж, томилогдсон бүрэлдэхүүн удирдамжийн дагуу “Хүүхэд хамгаалал, болзошгүй эрсдэлээс хамгаалах, аюулыг илрүүлэх, арилгах” арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ сургуулийн хүүхдүүдэд Хүнсний аюулгүй байдал, хүнсийг хэрхэн сонгож хэрэглэх талаар мэдээлэл, сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаа.

1. Ерөнхий боловсролын 1-5 дугаар сургууль орчны 3 худалдааны газар, нарийн боов, сүү, бууз, баншны 3 цехийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 2 худалдааны газраас хадгалалтын хугацаа дууссан 149 ширхэг бохь, 9 ширхэг шоколад илэрснийг тухайн газар дээр нь устгуулж, 2 төрлийн хаяг, шошгын зөрчилтэй бүтээгдэхүүнийг лангуун дээрээс татан авхуулсан.
2. Стандартын шаардлага хангаагүй орчинд үйл ажиллагаа явуулсан нарийн боовны 1 цехийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоож ажилласан.
3. Ерөнхий боловсролын Говийн ирээдүй сургуулийн 87 сурагч, Хүмүүнлэг сургуулийн 72 сурагч, Мандал сургуулийн 175 сурагч, Эрдмийн далай сургуулийн 182 сурагч, Хүмүүнлэг сургуулийн 72 сурагчдад сургалт зохион байгуулллаа.
4. “Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүн”, “Хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгыг хэрхэн унших”, “Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах сахар, давс, өөх тосны агууламж”, “Хүний өдөрт авах илчлэг, сахар, давс, өөх тосны хэмжээ”, “Худалдааны газруудын хүнсний бүтээгдэхүүн хадгалах горим”-ын талаарх сургалтыг 3-5 дугаар ангитай нийт 4 сургуулийн 516 сурагчид зохион байгуулсан.
5. Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнээр зөвлөмж бэлтгэж, байгууллагын веб сайтад байршуулж, иргэдийг мэдээллээр ханган ажилласан.

ХЯНАСАН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА

Б.МӨНХЖАРГАЛ

НЭГТГЭН ТАЙЛАГНАСАН
ЗАХИРГАА АЖ АХУЙ АЛБАНЫ ДАРГА

Ж.ШИНЭ-УЯНГА

2. Стандартын шаардлага хангаагүй орчинд үйл ажиллагаа явуулсан нарийн боовны 1 цехийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зогсоож ажилласан.
3. Ерөнхий боловсролын Говийн ирээдүй сургуулийн 87 сурагч, Хүмүүнлэг сургуулийн 72 сурагч, Мандал сургуулийн 175 сурагч, Эрдмийн далай сургуулийн 182 сурагч, Хүмүүнлэг сургуулийн 72 сурагчдад сургалт зохион байгууллаа.
4. "Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүн", "Хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгыг хэрхэн унших", "Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах сахар, давс, өөх тосны агууламж", "Хүний өдөрт авах илчлэг, сахар, давс, өөх тосны хэмжээ", "Худалдааны газруудын хүнсний бүтээгдэхүүн хадгалах горим"-ын талаарх сургалтыг 3-5 дугаар ангитай нийт 4 сургуулийн 516 сурагчид зохион байгуулсан.



5. Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүнээр зөвлөмж бэлтгэж, байгууллагын веб сайтад байршуулж, иргэдийг мэдээллээр ханган ажилласан.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГА



Б.МӨНХЖАРГАЛ

НЭГТГЭН ТАЙЛАГНАСАН ЗАХИРГАА
АЖ АХУЙ АЛБАНЫ ДАРГА

Ж.ШИНЭ-УЯНГА